



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор Ү
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль шинээр батлагдсан, хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг бэхжүүлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д дор дурдсан агуулгатай 1.5 дахь хэсгийн 11/, 6.5 дахь заалтуудыг нэмсүгэй:

1/ “1.5 дахь хэсгийн 11/. Өөрийн хөрөнгө гэдэг нь активаас өр төлбөрийг хассан зөрүү буюу хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн нийлбэрийг.”;

2/ “6.5. Хорооны 2012 оны дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-д заасны дагуу зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаагүй үндэслэлээр тухайн ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тайлант хугацааны эхлэлийг энэ журмын 6.3-д заасан хугацаанаас хойш тооцно.”.

2. Мөн журмын 1.1, 1.5 дахь хэсгийн 6/, 3.2 дахь хэсгийн 2/, 3/, 4/, 4.1, 4.4, 4.5 дахь хэсгийн 8/, 6.1, 6.4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ “1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.7 дахь заалтад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-нд дагаж мөрдөх санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг тодорхойлох болон бусад хэм хэмжээг тогтоох түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.”;

2/ “1.5 дахь хэсгийн 6/. Хувь хөрөнгө гэдэг нь гишүүд эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор ХЗХ-нд элсэхэд оруулсан мөнгөн хөрөнгийг;”;

3/ 3.2 дахь хэсгийн 2/, 3/, 4/ дэх заалтууд:

“2/. ХЗХ-ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт активын 20 хувиас хэтрэхгүй байвал зохино.

3/. Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн хэмжээ нь нийт хувь хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байвал зохино.

4/. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр ашгаас байгуулах нөөцийн сан нь хоршоологчдын өмчийн 15 хувиас доошгүй байвал зохино.”;

4/ “4.1. ХЗХ болон тухайн ХЗХ-г хариуцсан ажилтнаас дор дурдсан өгөөж, харьцаануудыг тооцож, ХЗХ-дын нэгтгэлийн дундажтай харьцуулан санхүү, төлбөрийн чадвар болон бусад үзүүлэлтэд үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:”;

5/ “4.4. Активын өгөөж нь нэг төгрөгийн актив хөрөнгөөс ямар хэмжээний орлого олж байгааг харуулах бөгөөд татварын өмнөх цэвэр ашгийг нийт активын дундажтай харьцуулан тооцно.”;

6/ “4.5 дахь хэсгийн 8/. Зээлийн эрсдэлийн сан, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа: Зээлийн эрсдэлийн санг нийт зээлийн өрийн үлдэгдэлд тус тус харьцуулан дүгнэлт хийнэ.”;

7/ “6.1. Энэхүү журамд заагдсан зохистой харьцааг ханган ажиллаж байгаа эсэхэд ХЗХ-ны бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон ХЗХ-ны дарга, гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналт тавьж, хангуулахтай холбогдуулан зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана.”;

8/ “6.4. Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан журам мөрдөгдөж эхэлснээс хойш хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ХЗХ нь Хорооноос тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойшхи 2 улиралд багтаан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байх үүргийг хүлээнэ.”;

3. Мөн журмын 1.2 дахь хэсгийн “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо /цаашид “Хоршоо” гэх/” гэснийг “ХЗХ” гэж, 1.2.2 дахь заалтын “Актив хөрөнгийн” гэснийг “Активын”, 1.2 дахь хэсгийн 4/ дэх заалтын “Төлбөрийн” гэснийг “Төлбөр”, 1.3, 1.4, 6.2 дахь заалтын “хоршоо” гэснийг “ХЗХ” гэж, 1.4 дэх заалтын “Хоршооны” гэснийг

“Хадгаламж, зээлийн хоршооны” гэж, 1.5 дахь хэсгийн 1/, 2/, 3/, 5/, 7/, 2.2, 2.9, 3.1 дэх хэсгийн 3/, 4.3, 4.5 дахь заалтуудын “хоршооны” гэснийг “ХЗХ-ны” гэж, 1.5 дахь хэсгийн 8/ дахь заалтын “гүйцэтгэж чадах” гэснийг “гүйцэтгэх” гэж, 2.1 дэх заалтын “банкин” гэснийг “банк, санхүүгийн байгууллага” гэж, 2.9 дэх заалтын “түүнд холбогдох” гэснийг “нэгдмэл сонирхолтой” гэж, 2 дугаар бүлгийн гарчгийн болон 3.1 дэх хэсгийн 1/, 2/ дахь заалтын “актив хөрөнгийн” гэснийг “активын” гэж, 3.1 дэх хэсгийн 3/ дахь заалтын “5” гэснийг “10” гэж, 3.2 дахь хэсгийн 1/ дэх заалтын “80” гэснийг “20-80” гэж, 4.3 дахь заалтын “5 хувиас бага” гэснийг “15 хувиас хэтрэхгүй” гэж, 6.2 дахь хэсгийн 6/ дахь заалтын “бүтэц” гэснийг “бүтцийн үзүүлэлтийн тайлан” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Мөн журмын 1.5 дэх хэсгийн 9/ дэх заалтын “...банк...” гэсний дараа “, санхүүгийн байгууллага...” гэж, 1.5 дахь хэсгийн 10/ дахь заалтын “...зээл...” гэсний дараа “, төсөл, хөтөлбөрийн зээл...” гэж, 6.2 дахь хэсгийн 8/ дахь заалтын “... хэмжээний” гэсний дараа “үзүүлэлтийн...”, 6.2 дахь хэсгийн 9/ дэх заалтын “...чадварын” гэсний дараа “үзүүлэлтийн...” гэж тус тус нэмсүгэй.

5. Мөн журмын 1.5 дахь хэсгийн 1/, 2.1 дэх хэсгийн “...хөрөнгө...” гэснийг, 1.5 дахь хэсгийн 7/ дахь заалтын “...нийлүүлсэн...” гэснийг, 2.8 дахь заалтын “Зээлийн багцын чанарыг тооцож гаргахдаа зээлийн ангилал (хэвийн зээл, хугацаа хэтэрсэн зээл, хэвийн бус зээл, эргэлзээтэй зээл, муу зээл) тус бүрийг нийт зээлийн өрийн үлдэгдлийн дүнд харьцуулна.” гэснийг, 3.2 дахь хэсгийн 1/ дэх заалтын “...хоршоонд...” гэснийг, 4.5 дахь заалтын “...орлого, зарлагын тайлангаар...” гэснийг, 4.5 дахь хэсгийн 1/, 2/, 3/, 4/, 5/, 6/, 7/ дахь заалтын “...харьцуулна” гэснийг, 6.2 дахь хэсгийн 1/, 3/ дахь заалтын “Хоршооны” гэснийг тус тус хассугай.

6. Мөн журмын 4.2 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

7. Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН